



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 04 өдөр

Дугаар А/396

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 3/03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Жаргалант сумын Бичигт багийн 8 дугаар гудамж 80 тоот газар өмчлөгч Баасанхүү овогтой Даваажаргал, Бичигт багийн 8 дугаар гудамж 46 тоот газар өмчлөгч Цэвээн овогтой Балжинням нарын “Авто замын трасст орсон 2 айлын газар чөлөөлөлтийн зардалд зориулан 40 000 000 төгрөгийг хавсралтаар баталж зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулах 40 000 000 төгрөг /дөчин сая/-ийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 3/03 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтын 5.12-д “Авто замын трасст орсон айлын газар чөлөөлөлтийн зардал /Жаргалант сум/-аас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Ч.Багдал, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга Б.Баярсүх нарт зөвшөөрсүгэй.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ